



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/311

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу Гүрцэдэн овогтой Баатарын эзэмшлийн Хэрлэн сумын 3 дугаар баг /Баянмөнх/, Пунцагийн гудамж Д-22 тоотод байрлах, Үйлчилгээний зориулалттай 700 м² газрыг иргэн Отгонбаяр овогтой Анхбаярт 46 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Иргэн О.Анхбаярын эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

36 Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгосн гэрээ байгуулж, биелэлтэд хяналттавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зохиулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг Иргэн О.Анхбаярт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбо дуулан аймгийн Засаг даргын 2005 оны 35 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА